



**БУЯНТ-УХАА ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

Захиалагч:

YAG-ын САГ-ын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 11263533

Аудитын менежер
Г.Гүнжидмаа
Утас:99998431

Аудитор
П.Амарсанаа
Утас:99075330

Монгол Улсын Үндэсний
Аудитын Газар
Засгийн газрын IV байр, Бага
тойруу-6, Улаанбаатар-46, Монгол
улс
Вэб хуудас: www.audit.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч:

“Номгон Аудит” ХХК

Гүйцэтгэх захирал
Г.Саранчимэг
Утас:70100023
Гар утас: 89891034
Цахим хаяг:
nomgonaudit@yahoo.com

Аудитор
О.Мандах
Аудиторын туслах
А.Шийрэв

Хаяг: Чингэлтэй дүүрэг, Жуулчны
гудамж, Тайваны төв, 409 тоот

Аудитын тайлан

Хавсралт 1. Агуулга

Хавсралт 2. Аудитын гэрчилгээ

Хавсралт 3. Менежментийн захидал

Хавсралт 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5. Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Агуулга

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	1
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин	1
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	2
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	3
5. Материаллаг байдал.....	3
6. Дотоод хяналт.....	3
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар.....	3
8. Шилэн дансны мэдээлэл.....	4
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	4
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар.....	4
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	4
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	5
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	6
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	6
16. Аудитын гэрчилгээний дүгнэлт.....	6

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8.9.1 -д заасны дагуу Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /УАГ-САГ/2018/100/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Буянт-Ухаа дахь гаалийн газар 2017 оны санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 02 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн “Номгон Аудит” ХХК-ний аудитор О. Мандах аудитын багийг ахлан хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Буянт-Ухаа дахь гаалийн газрын төсвийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 31-нд “Номгон Аудит” ХХК-д ирүүлсэн байна. “Номгон Аудит” ХХК нь аудитыг 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 02 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаа сарын 23-нд Буянт-Ухаа дахь гаалийн газрын удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Буянт-Ухаа дахь гаалийн газрын төсвийн захирагч нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай”, “Гаалийн тухай”, “Татварын тухай”, “Нийгмийн даатгалын тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Шилэн дансны тухай”, “Хөдөлмөрийн тухай” хуулиуд болон УСНББОУС, бусад холбогдох хууль эрхийн актууд, УИХ, Засгийн газрын тогтоол, салбарын сайдын тушаал, Сангийн сайдын тушаалууд, заавар, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Буянт-Ухаа дахь гаалийн газар нь үйл ажиллагааныхаа эрхэм зорилгыг “Гаалийн хуулийн хэрэгжилтийг хангаж, гадаад худалдааны аюулгүй байдлыг ханган, хууль ёсны худалдааг хөнгөвчлөх эрсдлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлж, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх явдал юм” гэж тодорхойлсон байна.

Буянт-Ухаа дахь гаалийн газар нь Гаалийн ерөнхий газраас 2017 онд дэвшүүлсэн “Мэдээлэлд суурилсан, техник технологид тулгуурласан гаалийн хяналтын жил” уриан дор 2017 онд үйл ажиллагааны чиглэлээр 32 ажил төлөвлөн, төлөвлөсөн ажлаа бүрэн биелүүлж 94 хувь буюу А үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Буянт-Ухаа дахь гаалийн газар нь тайлант онд Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/39 тоот тушаалаар батлагдсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дагуу 5 алба, төрийн тусгай албан хаагч 142, төрийн үйлчилгээний 15, нийт 157 ажилтантайгаар, олон улсын нисэх онгоцны буудал, карго терминаль, катеринг, гаалийн баталгаат агуулах, гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар зэрэг гаалийн хяналтын бүсдүүдэд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Байгууллагын үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхийн тулд “Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Буянт – Ухаа дахь гаалийн газрын дарга төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх төсвийг батлагдсан төсвийн хүрээнд сар бүр хувиарлан Төв төрийн сангаас эрх нээн санхүүжүүлж байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд салбарын гол хэрэглэгддэг хууль тогтоомжоос гадна Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Буянт-Ухаа дахь гаалийн газрын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 17 -г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт батлах тухай” Гаалийн ерөнхий газрын 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар батлан мөрдөж байгаа боловч тухайн оноос хойш нэмэлт шинэчлэлт хийгээгүй байна.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Буянт-Ухаа дахь гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Юникус санхүүгийн програмаар боловсруулан, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5. Материаллаг байдал: Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлын суурийг орчин нөхцөл шинж чанарын хувьд материаллаг шинжтэй зүйлс илрээгүй ба эрсдэл бага гэж үнэлсэн тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын нэг хувиар тооцов. Үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,765,909.2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь 27,659.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа. Тухайн байгууллагад гүйцэтгэлийн горимын шалгалтаар илэрч байгаа зөрчлийн ихэнх хувийг цалингийн зардалтай холбоотой ажил гүйлгээ эзэлж байгааг үндэслэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас эрсдлийг тооцсон болно.

6. Дотоод хяналт : Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Буянт-Ухаа дахь гаалийн газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтыг Гаалийн ерөнхий газрын хяналт шинжилгээ дотоод аудитын хэлтэс хэрэгжүүлдэг байна.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэнээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс 2,588,615.10 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 3,300.00 мянган төгрөгийн нийт 2,591,915.10 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал зардалд 2,588,493.90 мянган төгрөг зарцуулж, 3,577.10 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

8. Шилэн дансны мэдээлэл: Буянт ухаа дахь гаалийн газар нь Монгол Улсын “Шилэн дансны тухай” хуулийн хүрээнд шилэн дансны мэдээллийг <https://shilendans.gov.mn/org/696> цахим хуудсаар шилэн данс гэсэн бие даасан цэстэй хүргэсэн байна. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 8 төрлийн мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалттай холбоотой 5 төрлийн мэдээлэл, бусад төрлийн 6 мэдээлэл тус тус байршуулсанаас байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг тухай бүр бөглөх хавсралт 23 дугаар маягтыг 5 удаа хугацаа хоцроон мэдээлсэн байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу тохиолдох магадлалтай уламжлалт эрсдэлүүдээс 8 данс 21 уламжлалт эрсдэлт, хяналтын эрсдэлүүдээс 8 данс 20 хяналтын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлбол: Аудитын гүйцэтгэлээр төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж авч үзсэн эрсдлүүдээс төсвийн хөрөнгийн зарцуулалт түүний дотор цалин хөлстэй холбоотой зөрчил нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “эрх ба үүрэг”, “хамааралтай байх”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Буянт-Ухаа дахь гаалийн газрын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, түрээс, шатахуун, харуул хамгаалтын зардал, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Буянт-Ухаа дахь гаалийн газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Илүү цагийн хөлс олгох тухай” А/80 дугаар тушаалаар илүү цагийн хөлс нийгмийн даатгалын шимтгэлийн хамт нийт 23,455.5 мянган төгрөгийн зардалтай холбоотой тушаал шийдвэр, анхан шатны болон дэмжих баримтыг шалгахад баримт дутуу бүрдүүлж 17,140.80 мянган төгрөг илүү цагийн хөлс олгосон, ажилд томилогдоогүй, чөлөөтэй, тушаалаар өөр газар томилогдсон 4 албан хаагчид 1- 4 дүгээр саруудад илүү цагаар ажилласан цагийн тооцоо хийж 792.2 мянган төгрөгийн илүү цагийн хөлс бодсон, 1-12 дугаар сарын цагийн бүртгэлд илүү цагаар ажилласан бүртгэл хөтлөөгүй, тушаалд заагдсан гаалийн байцаагчаас өөр албан тушаалтай ажилчдыг тушаалын хавсралтанд оруулсан, 4 албан хаагчид илүү цагийн хөлсийг тушаал гаргахаас өмнө олгосон зэрэг зөрчлүүд илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д, “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг тус тус үндэслэн 792.2 мянган төгрөгийн илүү цагийн хөлс бодсон зөрчилд акт бичих,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13 дугаар зүйлийн 13.7-д, “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Гаалийн тухай хуулийн 286 дугаар зүйлийн 286.3-д “гаалийн бүрдүүлэлтийг энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд хийх боломжгүй тохиолдолд гаалийн газар хорооны даргын шийдвэрээр гаалийн улсын байцаагчийг ажлын бус цагаар ажиллуулна” гэсэн заалтуудыг үндэслэн илүү цагийн хөлстэй холбоотой тушаал шийдвэр, анхан шатны болон дэмжих баримтыг бүрдэл дутуу 17,140.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон зөрчилд албан шаардлага өгөх.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны журмыг мөрдөөгүй, гэрээ байгуулаагүй, жилийн дүнгээр 21,189,0 мянган төгрөгийн шатахууныг Петровис ХХК-иас шууд худалдан авалт хийсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 8 дугаар зүйлийн “Худалдан авах ажиллагааны журмыг сонгох” заалт, Монгол Улсын Засгийн газрын “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аудитын зөвлөмж өгөх.

12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Аудитын явцад анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Буянт-Ухаа дахь гаалийн газар 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар гүйцэтгэлийн үед үр дүнгийн тайлангийн нийт зардал 1 хувь 27,659.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон.

Материаллаг 17,933.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнээс 17,140,8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 792,2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийг барагдуулах акт тогтоохоор төсөл бэлтгэсэн.

Материаллаг бус 21,189,0 мянган төгрөгийн зөрчил илэрч менежментийн захидлаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Б энд С Аудит” ХХК хийж, менежментийн захидлаар удирдлагад нийт 4,646.5 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг тооцож олгохдоо унаа хоолны мөнгийг дундаж цалинд оруулсан, бараа материалыг шууд зардалд бичсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлсэн, байна.

Ээлжийн амралтын цалинг тооцож олгохдоо дундаж цалинд хоол унааны хөнгөлөлтийг оруулж тооцсон зөрчлийг арилгаж амралтын цалингийн тооцоог журмын дагуу бодож олгосон.

Бараа материал шууд зардалд бичсэн, автомашины сэлбэг хэрэгслийн зардлын ажил гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу байсныг аудит хийх явцад зөрчлийг арилгаж зөвлөмжийн биелэлтийг бүрэн ханган ажилласан байна.

16. Зөрчилгүй санал дүгнэлт:

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт/, мөнгөн гүйлгээ, болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн

тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын тайланг

Бэлтгэсэн: Аудитор

О.Мандах

Анхан шатанд хянасан:

Чанарын хяналтын менежер

Б.Давгабазар

Хянасан:

Захирал

Г.Саранчимэг

**БУЯНТ-УХАА ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН
ДАРГА С. ЦЭЦГЭЭ ТАНАА**

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт/, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**

Ц. НАРАНЧИМЭГ

**БУЯНТ-УХАА ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Бараа материалын талаар

Менежментийн захидал

Аудитын ажил гүйцэтгэх гэрээгээр “Номгон аудит” ХХК-ийн илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Буянт-Ухаа дахь гаалийн газрын гүйцэтгэх удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал, дүгнэлт гаргахад зориулагдсан. Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Бидний энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Буянт-Ухаа дахь гаалийн газрын удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1. Бараа материал	Тэргүүлэх ач холбогдол №1
<u>Ажиглалт</u> Худалдан авах ажиллагааны журмыг мөрдөөгүй, гэрээ байгуулаагүй 21,189.0 мянган төгрөгийн шатахууныг Петровис ХХК – аас шууд худалдан авалт хийсэн нь Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 8 дугаар зүйл. “Худалдан авах ажиллагааны журмыг сонгох” заалт, Монгол Улсын Засгийн газрын “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.	<u>Зөвлөмж</u> Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 8 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолыг тус тус бүрэн хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна. Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.
<u>Эрсдэл</u> 1. Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх 2. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй байх	<u>Үйлчлүүлэгчийн хариу</u> Буянт-Ухаа дахь гаалийн газар нь 2018 оны 02 сарын 12, 22-ны өдрийн №02/79, 02/94 дугаар албан бичгээр тайлбар ирүүлсэн болно.